

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** САГ-2026/30/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот  
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг  
Утас: 51-261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Энхдалай  
Утас: 51-260512 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](mailto:enkhdalaid@audit.gov.mn)

Аудитор Ж.Мөнхбилгүүн  
Утас: 51-261628 Цахим хаяг: [munkhbilguunj@audit.gov.mn](mailto:munkhbilguunj@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:  
Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа  
Цахим хаяг: [dabg.audit@gmail.com](mailto:dabg.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	10
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	11
3.1 Компани, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	13
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин .....	13
3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	13
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл .....	15
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	20
5.1 Албан шаардлага .....	20
5.2 Зөвлөмж .....	22
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	24

**Товчилсон үгийн жагсаалт**

ААНБОАТ	Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТҮТ	Авто тээврийн үндэсний төв
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/727  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7,982.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

1. Тайлант оны нийт орлогын төлөвлөгөө 69.4 хувийн гүйцэтгэлтэй, 5,476.3 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан, эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг оновчтой төлөвлөөгүй;
2. Санхүүгийн тайлангийн авлагын дансны үлдэгдэлд 59 байгууллага, хувь хүмүүсийн 749.4 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. Авлагын дансны нийт үлдэгдлээс түүвэрлэн 4 байгууллагын үлдэгдлийг тулган баталгаажуулахаар хүргүүлсэн захидлыг харилцагч, бэлтгэн нийлүүлэгчдэд явуулаагүй, аудитын хугацаанд хариу ирүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”; 11 дүгээр зүйлийн 11.3-т “төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн ба зөв батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### **Асуудлын онцлон тэмдэглэсэн хэсэг**

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ нь 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 173.98 км 22 авто зам, гүүрийн барилгын ажилд техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг 3,294.0 сая төгрөг буюу 75.0 хувьтай гүйцэтгэсэн байна.

### **Асуудлын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ нь Багахангай өртөөнөөс Төв аймгийн Хөшигийн хөндийн “Эдийн засгийн чөлөөт бүс, үйлдвэржилт, тээвэр логистикийн бүс хүртэл” төмөр замын трассын дагуу Төмөр замын төслийн хүрээнд техник, технологийн хяналт тавих, лабораторийн туршилт шинжилгээний ажлыг гүйцэтгэхээр Монголын төмөр зам ТӨХК-тай АГГ-2025/75 дугаар 4,600.0 сая төгрөгийн гэрээг байгуулан, тайлант оны гүйцэтгэлээр 76.0 хувийн биелэлттэй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын конторын барилгын өргөтгөл, шинэчлэлийн ажлын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлын гэрээний дагуу боловсруулагдсан барилгын гадна, дотор ажлын зураг, төсвийг хариуцагч компаниар гаргуулах Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 101/ШШ2024/03277 дугаар шийдвэр бүрэн хэрэгжээгүй байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,051,160,870.44	3,129,900,132.25
1.1.2	Дансны авлага	521,436,828.17	2,806,909,717.87
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	3,118,750.16	3,153,407.32
1.1.4	Бусад авлага	10,100.00	-
1.1.6	Бараа материал	332,053,133.39	388,102,666.63
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	11,550,000.00	-
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>3,919,329,682.16</b>	<b>6,328,065,924.07</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,969,793,855.92	2,563,566,361.27
1.2.2	Биет бус хөрөнгө	826,599,408.90	824,847,954.30
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	33,764,645.38	36,792,231.75
1.2.8	Дуусаагүй барилга	1,343,713,417.91	1,343,713,417.91
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>5,173,871,328.11</b>	<b>4,768,919,965.23</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,093,201,010.27</b>	<b>11,096,985,889.30</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	119,072,341.54	100,094,924.09
2.1.1.3	Татварын өр	306,887,817.51	405,426,629.32
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>425,960,159.05</b>	<b>505,521,553.41</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	45,227,721.75	203,104,012.38
2.1.2.4	Хойшлогдсон орлого	535,856,409.13	465,789,924.85
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>581,084,130.88</b>	<b>668,893,937.23</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,007,044,289.93</b>	<b>1,174,415,490.64</b>
2.3	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: а) төрийн	1,012,811,105.36	1,012,811,105.36
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	993,475,310.70	989,846,564.03
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,840,862,938.71	1,840,767,240.76
2.3.9	Хуримтлагдсан ашиг /өмнөх үеийн/	4,239,007,365.57	4,247,441,572.24
2.3.10	Хуримтлагдсан ашиг /тайлант үеийн/	-	1,831,703,916.27
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>8,086,156,720.34</b>	<b>9,922,570,398.66</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>9,093,201,010.27</b>	<b>11,096,985,889.30</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>8,842,943,953.21</b>	<b>12,205,266,760.77</b>
2	Борлуулалтын өртөг	8,463,759,674.15	10,106,267,452.13
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>379,184,279.06</b>	<b>2,098,999,308.64</b>
5	Хүүний орлого	87,730,155.36	84,949,935.62
8	Бусад орлого	119,022,654.28	157,389,266.35
8.1	<b>Орлогын дүн</b>	<b>206,752,809.64</b>	<b>242,339,201.97</b>
10	Ерөнхий ба удирдлагын зардал	353,295,765.18	295,714,924.86
12	Бусад зардал	34,486,150.00	9,359,390.91
12.1	<b>Зардлын дүн</b>	<b>387,781,915.18</b>	<b>305,074,315.77</b>
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	13,388,250.00	-
17.1	<b>Олз, гарзын дүн</b>	<b>13,388,250.00</b>	-
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>211,543,423.52</b>	<b>2,036,264,194.84</b>
19	Орлогын татварын зардал	21,154,342.36	204,560,278.57
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>190,389,081.16</b>	<b>1,831,703,916.27</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>190,389,081.16</b>	<b>1,831,703,916.27</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>10,486,963,883.30</b>	<b>11,498,780,900.44</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	9,801,530,287.68	11,412,975,639.25
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,471,843.00	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	683,961,752.62	85,805,261.19
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>9,589,320,756.11</b>	<b>11,036,818,283.96</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,704,419,678.18	5,352,309,453.13
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	890,730,172.44	1,345,817,756.21
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	305,947,881.14	389,757,906.36
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	2,139,956,728.16	1,417,426,036.16
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	528,917,205.00	896,467,213.18
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	88,057.64	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	581,582,875.64	1,321,040,064.06
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	30,000,000.00	428,328.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,407,678,157.91	313,571,526.86
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>897,643,127.19</b>	<b>461,962,616.48</b>
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>58,143,260.41</b>	<b>84,707,937.76</b>
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	58,143,260.41	84,707,937.76
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>329,109,100.00</b>	<b>372,736,752.43</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	323,829,100.00	82,227,272.73
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,280,000.00	-
2.2.6	Бусад	-	290,509,479.70
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(270,965,839.59)</b>	<b>(288,028,814.67)</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>68,473,380.00</b>	<b>95,194,540.00</b>
3.2.4	Төлсөн ногдол ашиг	68,473,380.00	95,194,540.00
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(68,473,380.00)</b>	<b>(95,194,540.00)</b>
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>558,203,907.60</b>	<b>78,739,261.81</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,492,956,962.84</b>	<b>3,051,160,870.44</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>3,051,160,870.44</b>	<b>3,129,900,132.25</b>

**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**  
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,012,811,105.36</b>	<b>1,044,359,512.10</b>	<b>1,987,812,384.96</b>	<b>4,072,607,535.55</b>	<b>8,117,590,537.97</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(23,989,251.14)	(23,989,251.14)
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,012,811,105.36</b>	<b>1,044,359,512.10</b>	<b>1,987,812,384.96</b>	<b>4,048,618,284.41</b>	<b>8,093,601,286.83</b>
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(50,884,201.40)	-	-	(50,884,201.40)
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	(146,949,446.25)	-	(146,949,446.25)
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	190,389,081.16	190,389,081.16
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,012,811,105.36</b>	<b>993,475,310.70</b>	<b>1,840,862,938.71</b>	<b>4,239,007,365.57</b>	<b>8,086,156,720.34</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	8,434,206.67	8,434,206.67
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(3,628,746.67)	-	-	(3,628,746.67)
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,012,811,105.36</b>	<b>989,846,564.03</b>	<b>1,840,862,938.71</b>	<b>4,247,441,572.24</b>	<b>8,090,962,180.34</b>
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	(95,697.95)	-	(95,697.95)
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	1,831,703,916.27	1,831,703,916.27
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
<b>2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,012,811,105.36</b>	<b>989,846,564.03</b>	<b>1,840,767,240.76</b>	<b>6,079,145,488.51</b>	<b>9,922,570,398.66</b>

**Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын тайлан**

**2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл  
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон**

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйц	Хувь
<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</b>			<b>9,063,085.0</b>	<b>17,923,892.9</b>	<b>12,447,605.9</b>	<b>3,384,520.9</b>	<b>137.3</b>	<b>(5,476,287.1)</b>	<b>69.4</b>
1	Авто замын барилгын ажлын техник, технологийн хяналтын орлого	м.төг	4,218,329.1	4,420,600.0	3,294,031.6	(924,297.6)	78.1	(1,126,568.4)	74.5
	Авто замын засвар арчлалт хариуцсан компаниудын техник, технологийн хяналтын орлого	м.төг	1,261,947.7	1,220,939.1	1,353,857.9	91,910.2	107.3	132,918.8	110.9
	Лабораторийн сорил шинжилгээний ажил, тоног төхөөрөмжийн түрээс, замын чанар, байдлын судалгаа, дүгнэлтийн орлого	м.төг	321,001.3	380,000.0	410,065.1	89,063.8	127.7	30,065.1	107.9
	Техник ашиглалтын түвшин тогтоох ажлын орлого	м.төг	668,410.9	880,000.0	880,100.9	211,690.0	131.7	100.9	100.0
	Хөдөлгөөний эрчмийн судалгааны орлого	м.төг	319,909.1	150,000.0	91,017.3	(228,891.8)	28.5	(58,982.7)	60.7
	Эрдэм шинжилгээ судалгаа, стандарт, норм дүрэм боловсруулсаны орлого	м.төг	183,336.9	268,891.8	268,891.8	85,554.9	146.7	-	100.0
	Зураг төсөл төсвийн экспертизийн үйл ажиллагааны орлого	м.төг	1,870,009.0	1,135,825.7	2,640,164.9	770,155.9	141.2	1,504,339.2	232.4
	Төлбөр хураах цэгээс ЗХЗ, бусад орлого	м.төг	-	-	-	-	-	-	-
Төсөл арга хэмжээний орлого	м.төг	-	9,433,636.4	3,267,137.1	3,267,137.1	-	(6,166,499.3)	34.6	
Үйл ажиллагааны бусад орлого	м.төг	220,141.1	34,000.0	242,339.3	22,198.2	110.1	208,339.3	712.8	
<b>2 Нийт орлого</b>	<b>м.төг</b>	<b>9,063,085.0</b>	<b>17,923,892.9</b>	<b>12,447,605.9</b>	<b>3,384,520.9</b>	<b>137.3</b>	<b>(5,476,287.1)</b>	<b>69.4</b>	
<b>3 Нийт зардал</b>	<b>м.төг</b>	<b>8,851,541.6</b>	<b>17,507,559.0</b>	<b>10,411,341.8</b>	<b>1,559,800.2</b>	<b>117.6</b>	<b>(7,096,217.3)</b>	<b>59.5</b>	
Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	253,713.6	258,750.0	307,547.3	53,833.7	121.2	48,797.3	118.9	
<b>4 Татварын өмнөх ашиг</b>	<b>м.төг</b>	<b>211,543.4</b>	<b>416,333.9</b>	<b>2,036,264.1</b>	<b>1,824,720.7</b>	<b>962.6</b>	<b>1,619,930.2</b>	<b>489.1</b>	
<b>5 Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>м.төг</b>	<b>190,389.2</b>	<b>374,700.5</b>	<b>1,831,703.9</b>	<b>1,641,314.8</b>	<b>962.1</b>	<b>1,457,003.4</b>	<b>488.8</b>	
6	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	<b>м.төг</b>	<b>1,973,537.4</b>	<b>3,549,881.4</b>	<b>2,666,857.8</b>	<b>693,320.4</b>	<b>135.1</b>	<b>(883,023.6)</b>	<b>75.1</b>
	а/ Орлогын татварт	м.төг	14,769.7	41,633.4	9,631.2	(5,138.5)	65.2	(32,002.2)	23.1
	б/ НӨАТ	м.төг	690,803.3	1,635,774.3	726,213.6	35,410.3	105.1	(909,560.7)	44.4
	в/ НДШ	м.төг	890,730.1	1,013,029.4	1,345,817.9	455,087.8	151.1	332,788.5	132.9
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	352,370.1	820,034.1	539,541.7	187,171.6	153.1	(280,492.4)	65.8
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	18,692.1	30,000.0	40,292.3	21,600.2	215.6	10,292.3	134.3
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	6,172.1	2,610.2	2,130.7	(4,041.4)	34.5	(479.5)	81.6
ж/ Бусад татварт (улсын тэмдэгийн хураамж)	м.төг	-	6,800.0	3,230.4	3,230.4	-	(3,569.6)	47.5	
7 Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	57,116.7	112,410.2	95,194.6	38,077.9	166.7	(17,215.6)	84.7	
8 Нийт ажиллагсдын тоо	хүн	147.0	259.0	159.0	12.0	108.2	(100.0)	61.4	
9 Нийт цалингийн сан	м.төг	4,450,437.1	9,117,264.8	6,798,482.7	2,348,045.6	152.8	(2,318,782.1)	74.6	
10 Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	1,710.0	2,053.0	2,053.0	343.0	120.1	-	100.0	
11 Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.98	0.98	0.84	(0.14)	85.6	(0.1)	85.6	
12 Хөрөнгө оруулалт	м.төг	39,400.0	2,576,654.2	77,000.0	37,600.0	195.4	(2,499,654.2)	3.0	
13	<b>Нийт авлага</b>	<b>м.төг</b>	<b>569,880.3</b>	<b>294,635.0</b>	<b>2,810,063.1</b>	<b>2,240,182.8</b>	<b>493.1</b>	<b>2,515,428.1</b>	<b>953.7</b>
	Үүнээс: Найдваргүй	м.төг	89,575.0	64,139.5	64,139.5	(25,435.5)	71.6	-	100.0
14	<b>Нийт өглөг</b>	<b>м.төг</b>	<b>1,007,044.2</b>	<b>924,034.4</b>	<b>1,174,415.4</b>	<b>167,371.2</b>	<b>116.6</b>	<b>250,381.0</b>	<b>127.1</b>
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	425,960.1	474,535.6	505,521.5	79,561.4	118.7	30,985.9	106.5
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	581,084.1	449,498.8	668,893.9	87,809.8	115.1	219,395.1	148.8

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын үйл ажиллагааны үндсэн зорилт нь Монгол Улсын авто замын сүлжээний ашиглалтын бэлэн байдалд хяналт тавих, зам засвар, арчлалтын ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавих, зам тээврийн чиглэлээр эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхлэх, стандарт, норм нормативын баримт бичиг боловсруулах, авто зам, замын байгууламжийн зураг төслийн магадлалын үйл ажиллагааг зохион байгуулах, авто замын салбарын мэргэжилтэй ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах, авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын техник технологийн хяналт, төлбөр авах үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэхэд оршино.

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын эрхэм зорилго нь Монгол Улсын Автозамын тухай хуулийн 11 дүгээр зүйлд тусгасан чиг үүрэг болон Засгийн газраас зам тээврийн салбарын талаар баримталж буй бодлого шийдвэрийг хэрэгжүүлж, олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдлыг олон улсын жишигт хүргэхэд чиглэнэ. Тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд нийт 7 зорилтын 84 арга хэмжээг төлөвлөснөөс 94.2 хувийн биелэлттэй гэж тайлагнасан.

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ыг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 55 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан бөгөөд ТӨБЗГ-ын баталсан төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ нь Компанийн тухай хууль, Автозамын тухай хууль, автотээврийн тухай хууль, Барилгын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- ТӨБЗГ-ын 2025 оны 29 дүгээр тогтоолоор төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм, зохион байгуулалтын бүтцийн схем, албан тушаалын жагсаалт, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн баталсан;
- Захирлын 2025 оны А/12 дугаар тушаалаар Захирлын зөвлөлийн ажиллах журмыг баталсан.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

ТӨБЗГ-ын 2025 оны 29 дүгээр тогтоолоор баталсан бүтэц орон тоонд шинээр дотоод аудитын орон тоог батлуулсан. Төвийн захирлын 2024 оны 12 дугаар сарын А/130 дугаар тушаалаар дотоод аудитын ажиллах журмыг баталж, 2025 оны 5 дугаар сараас ажилтнуудыг томилсон байна.

Дотоод аудитын тайлант оны төлөвлөгөөнд дотоод аудит, санхүүгийн хяналт, сургалт, мэргэжил арга зүй, бусад чиглэлээр нийт 30 ажил төлөвлөж, төлөвлөгөөт 24, төлөвлөгөөт бус 25 ажил, шалгалт хийсэн талаар төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг аудитад ирүүлсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, Захирлын 2024 оны А/96 дугаар тушаалаар батлан мөрдөж байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан сайжруулах зөвлөмж өгсөн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,003.8 сая төгрөгөөр буюу 22.0 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,051,160.9	3,129,900.1	78,739.3
Дансны авлага	521,436.8	2,806,909.7	2,285,472.9
Татвар, НДШ-ийн авлага	3,118.8	3,153.4	34.7
Бусад авлага	10.1	-	(10.1)
Бараа материал	332,053.1	388,102.7	56,049.5
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	11,550.0	-	(11,550.0)
Үндсэн хөрөнгө	2,969,793.9	2,563,566.4	(406,227.5)
Биет бус хөрөнгө	826,599.4	824,848.0	(1,751.5)
Хойшлогдсон татварын хөрөнгө	33,764.6	36,792.2	3,027.6
Дуусаагүй барилга	1,343,713.4	1,343,713.4	-
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>9,093,201.0</b>	<b>11,096,985.9</b>	<b>2,003,784.9</b>
Богино хугацаат өр төлбөр	425,960.2	505,521.6	79,561.4
Урт хугацаат өр төлбөр	581,084.1	668,893.9	87,809.8
Эздийн өмч	8,086,156.7	9,922,570.4	1,836,413.7
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>9,093,201.0</b>	<b>11,096,985.9</b>	<b>2,003,784.9</b>

Дээрх хүснэгтээс харахад авлага, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөр, эздийн өмчийн данснуудад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 3,129.9 сая төгрөг болж 78.7 сая төгрөгөөр өссөн нь Богд банкин дахь хадгаламжийн дансны үлдэгдэл 54.0 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан;

2. Авлагын үлдэгдэл 2,810.1 сая төгрөг болж 2,285.5 сая төгрөгөөр өссөн нь Монголын төмөр зам ТӨХК-ийн гэрээний үлдэгдэл төлбөр 1,654.7 сая төгрөгийн борлуулалтын авлага үүссэн нь голлон нөлөөлсөн;
3. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,563.6 сая төгрөг болж 406.2 сая төгрөгөөр буурсан байна. Тухайлбал:
  - ТӨБЗГ-ын 2025 оны 25 дугаар тогтоолоор 26 нэрийн 38.1 сая төгрөг, 519 дүгээр тогтоолоор 24 нэрийн 252.0 сая төгрөг, нийт 290.1 сая төгрөгийн ашиглалтын шаардлага хангахгүй болсон үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан, тайлант оны элэгдлийн зардлын дүн 391.5 сая төгрөгөөр тус тус буурсан,
  - Тайлант оны худалдан авалт 77.0 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2025 оны 621 дүгээр тогтоолоор 67.2 сая төгрөг, 2023 оны А-1/1478 тогтоолоор 131.1 сая төгрөгийн 2 автомашиныг балансаас балансад хүлээн авч, нийт 275.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь нөлөөлсөн;
4. Богино хугацаат өр төлбөр 505.5 сая төгрөг болж 79.5 сая төгрөгөөр өссөн нь жилийн эцэст татвар, өглөг дансны өрийг төлөөгүй нь нөлөөлсөн;
5. Урт хугацаат өр төлбөр 668.9 сая төгрөг болж 87.8 сая төгрөгөөр өссөн нь балансаас балансад шилжин ирсэн хөрөнгүүдийг орлогын аргаар хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой;
6. Эздийн өмч дансны үлдэгдэл 9,922.6 сая төгрөг болж 1,836.5 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 3.6 сая төгрөг, өмнөх үеийн үр дүнгийн залруулгын зөрүү 8.4 сая төгрөг, тайлант оны цэвэр ашиг 1,831.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тус тус нөлөөлсөн байна.

*Хуримтлагдсан үр дүнгийн дансанд хийсэн залруулга:*

- Тайлант онд хуримтлагдсан үр дүнгийн дансыг ТӨБЗГ-т төлсөн 2024 оны ногдол ашиг 95.2 сая төгрөгөөр бууруулан;
- Нийслэлийн татварын газрын маргаан таслах зөвлөлийн 2023 оны 08 дугаар тогтоолыг үндэслэн буруу ногдуулсан нэмэгдсэн өртгийн албан татварын өглөгийг 100.0 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүний хэрэгжилт 3.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж залруулсан байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

#### **3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө/техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2024 оны 729 дүгээр тогтоолоор тус компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 10,439.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 10,355.7 сая төгрөгөөр, 84.2 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,541.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ нь Хөшигийн хөндийн төмөр замын төслийн хүрээнд гүйцэтгэх ажилд техник, технологийн хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой төлөвлөгөөнд тодотгол хийлгэх хүсэлт гаргаж, ТӨБЗГ нь 2025 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 245 дугаар тогтоолоор тус төвийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгон, нийт орлогыг 17,923.9 сая төгрөг, нийт зардлыг 17,507.6 сая төгрөг, 416.3 сая төгрөгийн ашигтай ажиллахаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2,576.6 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

#### **3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр 12,447.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 10,411.3 сая төгрөгийн зардал гарган, 2,036.3 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 12,447.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 5,476.1 сая төгрөг буюу 30.6 хувиар тасарсан нь Хөшигийн хөндийн "Эдийн засгийн чөлөөт бус, үйлдвэржилт,

тээвэр логистикийн бүс хүртэл” төмөр замын трассын дагуу Төмөр замын төслийн хүрээнд гүйцэтгэх дараах ажлуудыг батлагдсан зураг төсөл, техникийн шаардлага, стандарт, норм, нормативын дагуу гүйцэтгэж байгаа эсэхэд техник, технологийн хяналт тавих, лабораторийн туршилт шинжилгээний ажлыг гүйцэтгэх гэрээг байгуулсны дараа буюу бодит орлогын дүнгээр төлөвлөгөөнд тодотгол хийгээгүйгээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 10,411.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 7,096.2 сая төгрөг буюу 40.5 хувиар дутуу зарцуулсан байна. Энэ нь ашиглалтад ороогүй оффисын шинэ барилгын ашиглалтын 62.1 сая төгрөг, төслийн гэрээтэй холбоотой 6,693.1 сая төгрөг, үйл ажиллагаанд гадаад томилолт, сургалт, зар сурталчилгаа, тэтгэмж тусламж, төлбөр хураамж, элэгдлийн зардлуудыг 338.9 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 28 төрлийн 240 нэрийн ажилд өөрийн эх үүсвэрээс 2,494.4 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 1,831.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,457.0 сая төгрөгөөр илүү байгаа нь төслийн болон элэгдлийн зардлыг илүү төлөвлөсөн нь нөлөөлжээ.

Тайлант онд ТӨБЗГ-т өмнөх оны ногдол ашгийн 95.2 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

## **СУДАЛГААНЫ ҮР ДҮН:**

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

### **1. Байгууллагын орон тооны цомхотголын талаар:**

ТӨБЗГ-ын 2024 оны 729 дүгээр тогтоолоор тус компанийн 2025 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд нийт 147 орон тоо баталж, 2025 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 245 дугаар тогтоолоор тодотголд орон тоог 259 болгон өөрчлөн баталжээ. Гүйцэтгэлээр сард дунджаар 168 орон тоотой ажиллаж, Монгол улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд заасан орон тоо бууруулах чиглэл, төсвийн зардлыг хязгаарлах, хэмнэх зорилтын дагуу 9 хувийн цомхотгол хийгээгүй байна.

### **2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:**

Захирлын 2025 оны А/01 дүгээр тушаалаар ажилтнуудын унааны нэмэгдлийг өдөрт 5,000.00 төгрөг, хоолны хөнгөлөлтийг 15,000.00 төгрөгөөр тооцож олгохоор 575.4 сая төгрөгийн төлөвлөгөө баталснаас 302.8 сая төгрөгийг зарцуулсан;

### **3. Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардлын талаар:**

Өмнөх аудитын 208/АО150053 дугаар төлбөрийн актаар ногдуулсан зар сурталчилгааны зардалд холбогдох шийдвэргүй зарцуулсан 3.9 сая төгрөгийг буруутай албан тушаалтан байгууллагын дансанд 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр төлж, байгууллагын хохирлыг бүрэн барагдуулсан байна.

### **4. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүнгийн талаар:**

Тайлант онд 28 удаагийн давхардсан тоогоор 323 ажилтанг 85.0 сая төгрөгийн сургалт семинарт хамруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 9 удаагийн сургалт, семинар зохион байгуулан, 54 ажилтнуудыг хамруулан 14.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

### **5. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээний талаар:**

Тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын төлөвлөгөөг 49.4 сая төгрөгөөр батлуулж, гүйцэтгэлээр 7 байгууллагатай гэрээ байгуулж, 40.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

**6. Программ хангамжийн бүртгэл, тайлагналын талаар:**

Тус төв нь лабораторийн цахим програм, эйбл, санхүүгийн программ, татварын зөрүүгийн бүртгэлийн зэрэг нийт 815.3 сая төгрөгийн өртөгтэй 9 программ хангамжийг үйл ажиллагаандаа ашигладаг байна.

**3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ нь тайлант онд 2,765.1 сая төгрөгийн төсөвтэй 25 худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн. Үүнээс 839.1 сая төгрөгийн 12 худалдан авалтыг зохион байгуулж, 44.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

*Хүснэгт 2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт*

№	Үзүүлэлт	Төлөвлөгөөний		Гүйцэтгэлийн			Зөрүү	
		тоо	дүн	тоо	дүн	хувь	тоо	дүн
1	Ажил	5	1,629,490.5	1	178,833.5	20.0	4	1,450,657.0
2	Бараа	16	996,363.5	8	562,933.4	50.0	8	433,430.1
3	Үйлчилгээ	4	139,200.0	3	97,330.0	75.0	1	41,870.0
<b>Дүн</b>		<b>25</b>	<b>2,765,054.0</b>	<b>12</b>	<b>839,096.9</b>	<b>48.0</b>	<b>13</b>	<b>1,925,957.1</b>

/мянган төгрөгөөр/

Тайлант онд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2,348.8 сая төгрөгийн 8 худалдан авалтыг НТШ-ын аргаар худалдан авахаар төлөвлөснөөс 544.6 сая төгрөгийн 2 худалдан авалтыг зохион байгуулж 25.0 хувийн гүйцэтгэлтэй, 311.8 сая төгрөгийн 6 худалдан авалтыг ХА-аар худалдан авахаар төлөвлөснөөс 232.2 сая төгрөгийн 6 худалдан авалт хийж 100.0 хувийн гүйцэтгэлтэй, 104.5 сая төгрөгийн 11 ШХА хийхээс 62.3 сая төгрөгийн 4 худалдан авалт хийж 36.4 хувийн гүйцэтгэлтэй, нийт 2,765.1 сая төгрөгийн 25 худалдан авалт хийхээр төлөвлөснөөс 839.1 сая төгрөгийн 12 бараа ажил үйлчилгээ худалдан авч, тайлант оны худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 48.0 хувь байна.

Нийт 12 бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 839.1 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

*Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилт*

№	Худалдан авалт	Төлөвлөгөөний		Гүйцэтгэлийн			Зөрүү	
		тоо	дүн	тоо	дүн	Хувь	тоо	дүн
1	Нээлттэй тендер шалгаруулалт	8	2,348,776.9	2	544,597.5	25.0	6	1,804,179.4
2	Харьцуулалт	6	311,780.1	6	232,175.5	100.0	-	79,604.6
3	Шууд худалдан авалт	11	104,497.0	4	62,323.9	36.4	7	42,173.1
<b>Дүн</b>		<b>25</b>	<b>2,765,054.0</b>	<b>12</b>	<b>839,096.9</b>	<b>48.0</b>	<b>13</b>	<b>1,925,956.1</b>

/мянган төгрөгөөр/

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах татварын программын бүртгэлийг үнэн зөв хөтлөх, татварын тодорхойлолтоорх өр төлбөрийг хамаарал бүхий нэгжүүдтэй тооцоо нийлж тайлагнах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Ди Эй Би Жи” Аудит ХХК-ийн аудитор С.Цэнгэлмаа, Ө.Ундармаа, мэргэжилтэн Ө.Гантулга нар гүйцэтгэж, захирал Н.Дэлгэрмаа, чанарын хяналтын менежер Д.Эрдэнэчимэг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Мөнхбилгүүн, аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/136 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний баталсан төлөвлөгөөний нийт зарлагын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны жилийн эцсийн Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний баталсан төлөвлөгөөний нийт зардал 17,507.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 175.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан байгууллагын хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан ажилласнаар 2025 оны зорилтот түвшинд баталсан зардлыг 40.5 хувиар буюу 7,096.3 сая төгрөгөөр бууруулан ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн шилэн дансны цахим хуудсанд тайлан, мэдээг иж бүрэн оруулаагүй зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг бүрэн тусгаж өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах аудитын зөвлөмж өгсөн.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 28 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

**Илрүүлэлт:** Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 28 төрлийн 170 мэдээг тогтоосон хугацаанд нь мэдээлсэн боловч оруулсан мэдээллийн чанар, үнэн зөв байдлыг шалгахад 1-ээс 11 дүгээр саруудын цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 490.7 сая төгрөг, орлогын 3,644.2 сая төгрөг, нийт 4,134.9 сая төгрөгийн гүйлгээг, түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарыг хавсаргаагүй, өмнөх аудитаар өгсөн 866/АО150053 дугаартай Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хууль 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх”, МУЕА-ын 2021 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.1.7-д “хавсралт дахь мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж 80-95 хувьтай бол зөвлөмж өгөх” гэсэнтэй тус тус нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Өмнөх оны аудитаар өгсөн зөрчил арилгах, таслан зогсоох албан шаардлагын хэрэгжилтийг хангах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжтой нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

**Илрүүлэлт 1:** Зам тээврийн яаманд 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 1/1570 дугаар албан бичгээр хүргүүлсэн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийг тусгасан ч гүйцэтгэлийг хувиар илэрхийлсэн. Мөн тайланд нийт төсөв болон гүйцэтгэлийн хувийг тайлагнаагүй, Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай уялдуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн тайлан нь түүний зорилтын саналтай харьцуулан дүгнэж болох ижил үзүүлэлттэй байх бөгөөд шаардлагатай мэдээллийг агуулсан байна” гэж заасантай нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх үзүүлэлтийг эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний болон санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдтэй уялдуулан дүгнэдэг болох зөвлөмж өгсөн.

**Илрүүлэлт 2:** Захирлын 2024 оны А/96 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж батлуулсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлого нь Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, холбогдох хууль тогтоомж болон байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нийцээгүй, санхүүгийн ажилтнуудад ашиглагдах гарын авлагын шаардлагыг хангаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нийцүүлж, нэмэлт зардал гаргахгүйгээр шинэчлэн ашиглах зөвлөмж өгсөн.

Тайлант онд хийгдсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг дүгнэх болон дагаж мөрдөх шалгуур үзүүлэлтүүд нь хууль тогтоомжийн заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, санхүүгийн тайлангийн авлага, өглөг, татварын дансдын эхний үлдэгдэл, орлого хүлээн зөвшөөрөлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн дансдын бүртгэл хөтлөлтөд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар 632.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс алдаа, зөрчил шийдвэрлэгдээгүй 357.2 сая төгрөгийн 2 асуудалд зөвлөмж өгөхөөр аудитын тайланд тусгасан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 6 алдаа, зөрчил илэрснээс 3.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 72.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн. Гүйцэтгэх захирлын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 1/333 дугаар албан бичгээр өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг ҮАГ-т ирүүлсэн байна.

Жилийн эцсийн аудитаар шалгагдагч байгууллага биелэлтийн тайланг нотлох баримт материалын хамт ирүүлснийг хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэж, үнэлсэн. Үүнд: 3.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 72.0 сая төгрөгийн 1 албан шаардлага бүрэн хэрэгжсэн, 1 зөвлөмжийн биелэлт 50.0 хувьтай тул албан шаардлага, 3 албан шаардлагын биелэлт 50.0 хувьтай буюу зөрчил давтагдсан тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		тоо	дүн	тоо	дүн	хувь
1	Зөвлөмж	1	-	1	-	50.0
2	Албан шаардлага	4	3,253,797.9	4	2,299,256.8	62.5
3	Төлбөрийн акт	1	3,940.9	1	3,940.9	100.0
<b>Нийт дүн</b>		<b>6</b>	<b>3,257,738.8</b>	<b>6</b>	<b>2,303,197.7</b>	<b>70.8</b>

Бүрэн хэрэгжээгүй дараах 3 зөрчилд өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлага хэрэгжээгүй давтан гарсан тул буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

- Тайлант онд 5,476.3 сая төгрөгийн 3 төрлийн орлогын төлөвлөгөө тасарсан;
- Автотээврийн үндэсний төвөөс лавлагаа авч Тээврийн хэрэгслийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулгахад лавлагаанаас 7 автомашин дутуу бүртгэсэн. Үүнээс 2 автомашин нь Авто замын засвар ашиглалтын нэгтгэл-Төв салбарт ашигладаг, зээлийн эх үүсвэрээр бэлтгэсэн 5 автомашиныг Зам тээврийн яамнаас бүртгэх зөвшөөрөл ирүүлээгүй учир хөрөнгөнд бүртгээгүй;
- Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд оруулах мэдээллийг хугацаанд нь оруулсан ч холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарыг хавсаргаагүй.

Ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн үндсэн хөрөнгүүдийн цаашид ашиглах хугацаа болон балансын үнийг шинэчлэн тогтоож, ашиглалтыг сайжруулах зөвлөмж бүрэн хэрэгжээгүй учир 1 албан шаардлага хүргүүлсэн.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудалд эрх бүхий байгууллагын анхааралд хандуулах дараах асуудлууд байна. Үүнд:

- Дэлхийн банкны МОН-3120 төслийн хөрөнгөөр бэлтгэсэн 5 нэрийн автозамын тусгай зориулалттай автомашин механизмын зээл төлөх эх үүсвэр, хөрөнгөөр бүртгэх шийдвэр гаргах;
- АЗЗА нэгтгэл-Төв аймгийн салбарт ашиглагдаж байгаа 2 автомашиныг ашиглах газарт нь хөрөнгөөр бүртгэх шийдвэр гаргах шаардлагатай байна.

Тус төвийн дараах нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг дараагийн аудитаар нарийвчлан шалгана. Үүнд:

- Тус төвийн конторын барилгын зураг, төсвийг хүлээлгэн өгөөгүй шүүхээр шийдэгдсэн ч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хүлээгдэж байгаа,
- Техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний гэрээгээр ажил гүйцэтгэж байгаа хувь инженерүүдийн гэрээний бүртгэл, зардлыг холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг тус тус шалгана.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 1,529.8 сая төгрөгийн нийт 5 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:*

1. Орлогын дэлгэрэнгүй тайлан, Эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшний төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан болон Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тайланд нийт орлогыг зөрүүтэй тайлагнасан;
2. ТӨБЗГ-ын шийдвэрээр балансаас балансад шилжин ирсэн 39.2 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 2 автомашиныг Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэсэн;
3. Хойшлогдсон татварын өр төлбөр данснаас хойшлогдсон татварын хөрөнгө дансанд зөрүүг шилжүүлэв гэсэн утгаар 24.6 сая төгрөгийг хааж бүртгэсэн;
4. Багахангай-Хөшигийн хөндийн төмөр замын барилга угсралтын техник, технологийн хяналтын үйлчилгээ үзүүлэх гэрээний орлогыг аккрузель сууриар тайлагнаагүй, гэрээ дүгнэсэн актаас 1,431.1 сая төгрөгийг зөрүүтэй тайлагнасан;
5. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 289 дүгээр тогтоолоор Автозамын тоног төхөөрөмж түрээс ТӨХК-аас шилжиж ирсэн 16 байгууллага, хувь хүмүүст нийт 34.9 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ аваагүй, тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 1.15-д "Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг" гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 7,982.5 сая төгрөгийн 6 зөрчил<sup>2</sup> илэрсэнд өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тайлант онд давтан гаргасан 5,476.1 сая төгрөгийн зөрчилд буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох 1 албан шаардлага, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй 1,756.7 сая төгрөгийн зөрчил, тайлант онд жилийн эцсийн мөнгөн хөрөнгө, авлагын дансаас түүвэрлэсэн харилцагчийн үлдэгдлийг тулган баталгаажуулах захидлын хариу ирүүлээгүй, авлагын дансдын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 749.4 сая төгрөгийн зөрчилд нийт 3 албан шаардлага хүргүүлж, татварын бүртгэлийн программыг жигдрүүлээгүй, татварын өр төлбөрийг тодорхойлолтоос зөрүүтэй тайлагнасан зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 7,982.5 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 175.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

**Илрүүлэлт 1.** Өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

1. Тайлант оны нийт орлогын төлөвлөгөөг 17,923.9 сая төгрөгөөр баталж, 12,447.6 сая төгрөгийн орлого тайлагнасан нь 69.4 хувийн гүйцэтгэлтэй, 5,476.3 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан. Энэ нь 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 867/АО150053 дугаартай өмнөх аудитаар хүргүүлсэн зорилтот түвшний төлөвлөгөөг оновчтой төлөвлөх, орлогын төлөвлөгөөг биелүүлэх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй;

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Үндсэн хөрөнгө-Авто тээврийн хэрэгслийн дэлгэрэнгүй бүртгэлд Автотээврийн үндэсний төвийн лавлагаанаас 7 автомашин дутуу бүртгэсэн. Үүнээс 2 автомашин нь Авто замын засвар ашиглалтын нэгтгэл-Төв салбарт ашигладаг, 5 автомашиныг ЗТЯ-наас бүртгэх зөвшөөрөл ирүүлээгүй нь өмнөх аудитаар хүргүүлсэн 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 869/АО150053 дугаартай байгууллагын нэр дээр бүртгэлтэй хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу шилжилт хөдөлгөөнийг хийн, бүртгэж тайлагнах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй;

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.3-т "эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16.1-д "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах"; 11 дүгээр зүйлийн 11.3-т "төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Өмнөх оны аудитаар өгсөн зөрчил арилгах, таслан зогсоох албан шаардлагуудын хэрэгжилтийг хангах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

**Илрүүлэлт 2.** Тайлант онд ажил гүйлгээ гарсан 4 банкны 7 харилцах, 2 хадгаламж, нийт 9 дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахаар хүргүүлсэн захидлыг банкуудад явуулаагүй, аудитын хугацаанд хариу ирүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 7-д "Банкны байгууллагаас бүх төрлийн харилцах дансны хуулгыг авах бүрдээ дансны гүйлгээг шалгаж, улирал бүрийн дансны үлдэгдлийг батлах" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Банкн дахь дансны үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

**Илрүүлэлт 3.** Санхүүгийн тайлангийн авлагын дансны үлдэгдэлд 59 байгууллага, хувь хүмүүсийн 749.4 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. Авлагын дансны нийт үлдэгдлээс түүвэрлэн 4 байгууллагын үлдэгдлийг тулган баталгаажуулахаар хүргүүлсэн захидлыг харилцагч, бэлтгэн нийлүүлэгчдэд явуулаагүй, аудитын хугацаанд хариу ирүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайлан дахь авлагын дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

**Илрүүлэлт 4.** Тайлант жилийн эцэст тоног төхөөрөмж дансанд 123 нэрийн 1,553.1 сая төгрөг, компьютер дагалдах хэрэгсэл дансанд 34 нэрийн 203.6 сая төгрөг, нийт 1,756.7 сая төгрөгийн бүртгэлээрх ашиглалтын хугацаа дуусч, анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна. Өмч хамгаалах зөвлөлөөс хөрөнгийн ашиглалтын хугацаа болон балансын үнийг шинэчлэн тогтоох саналыг хэлэлцэн боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хэмжигдэхүйц байх" зарчмыг баримтлан, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоогоогүй зөрчлийг арилгаж, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Татварын программыг ашиглан бүртгэлийг үнэн зөв хөтлөх:

**Илрүүлэлт:** Татварын бүртгэлийн программаарх бүртгэлийг аудитад ирүүлээгүй, программыг өөрийн байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн хөгжүүлээгүй, хөрөнгийг бүрэн ашиглаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 2-д "өмч хөрөнгө хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцана" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Программд өөрийн үйл ажиллагаанд нийцүүлэн шинэчлэл хөгжүүлэлт хийлгэж ашиглах, татварын бүртгэлийг үнэн зөв хөтлөх.

### 2.Татварын өр төлбөрийг барагдуулах, санхүүгийн тайланд татварын тодорхойлолтыг үндэслэн зөв тайлагнах:

**Илрүүлэлт:** Санхүүгийн тайлангийн татварын өр төлбөрийн үлдэгдлийг татварын тодорхойлолттой тулгахад зөрүүтэй тайлагнасан. Нэмэгдсэн өртгийн албан татварын болон Хувь хүний орлогын албан татварын өрийн зөрүүг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, 20.2.7-д “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө тусалцаа авах” гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Татварын тайлангаарх хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах, хамааралтай нэгжүүдтэй хоорондын тооцоог үнэн зөв хийж үлдэгдлийг баталгаажуулж байх.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
								Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орлогын дэлгэрэнгүй тайлан, Эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшний төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан болон Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тайланд нийт орлогыг зөрүүтэй тайлагнасан	1	-	1	-			1	-				
2	ТӨБЗГ-ын шийдвэрээр балансас балансад шилжин ирсэн 39.2 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 2 автомашиныг Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэсэн	1	39,240.9			1	39,240.9	1	39,240.9				
3	Хойшлогдсон татварын өр төлбөр данснаас хойшлогдсон татварын хөрөнгө дансанд зөрүүг шилжүүлэв гэсэн утгаар 24.6 сая төгрөгийг хааж бүртгэсэн.	1	24,589.4			1	24,589.4	1	24,589.4				
4	Багахангай-Хөшигийн хөндийн төмөр замын барилга угсралтын техник, технологийн хяналтын үйлчилгээ үзүүлэх гэрээний орлогыг аккрузель сууриар тайлагнаагүй, гэрээ дүгнэсэн актаас 1,431.1 сая төгрөгийг зөрүүтэй тайлагнасан.	1	1,431,060.0			1	1,431,060.0	1	1,431,060.0				
5	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 289 дүгээр тогтоолоор Автозамын тоног төхөөрөмж түрээс ТӨХК-аас шилжиж ирсэн 16 байгууллага, хувь хүмүүст нийт 34.9 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ аваагүй, тайлагнасан байна.	1	34,898.8			1	34,898.8	1	34,898.8				
<b>Дүн</b>		<b>5</b>	<b>1,529,789.3</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>1,529,789.3</b>	<b>5</b>	<b>1,529,789.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын тайлан

**6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд: Тайлант оны нийт орлогын төлөвлөгөөг 17,923.9 сая төгрөгөөр баталж, 10,984.6 сая төгрөгийн орлого тайлагнасан нь 61.0 хувийн гүйцэтгэлтэй, 6,939.3 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан. Энэ нь 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 867/АО150053 дугаартай өмнөх аудитаар хүргүүлсэн зорилтот түвшний төлөвлөгөөг оновчтой төлөвлөх, орлогын төлөвлөгөөг биелүүлэх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй; Үндсэн хөрөнгө-Авто тээврийн хэрэгслийн дэлгэрэнгүй бүртгэлд Автотээврийн үндэсний төвийн лавлагаанаас 7 автомашин дутуу бүртгэсэн. Үүнээс 2 автомашин нь Авто замын засвар ашиглалтын нэгтгэл-Төв салбарт ашигладаг, 5 автомашиныг ЗТЯ-наас бүртгэх зөвшөөрөл ирүүлээгүй нь өмнөх аудитаар хүргүүлсэн 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 869/АО150053 дугаартай байгууллагын нэр дээр бүртгэлтэй хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу шилжилт хөдөлгөөнийг хийн, бүртгэж тайлагнах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.	1	5,476,287.1							1	5,476,287.1		
2	Тайлант онд ажил гүйлгээ гарсан 4 банкны 7 харилцах, 2 хадгаламж, нийт 9 дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахаар хүргүүлсэн захидлыг банкуудад хүргүүлээгүй, аудитын хугацаанд хариу ирүүлээгүй.	1	-			1	-						
3	Санхүүгийн тайлангийн авлагын дансны үлдэгдэлд 59 байгууллага, хувь хүмүүсийн 749.4 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. Авлагын дансны нийт үлдэгдлээс түүвэрлэн 4 байгууллагын үлдэгдлийг тулган баталгаажуулахаар хүргүүлсэн захидлыг харилцагч, бэлтгэн нийлүүлэгчдэд хүргүүлээгүй, аудитын хугацаанд хариу ирүүлээгүй.	1	749,417.7			1	749,417.7						

**Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын тайлан**

4	Тайлант жилийн эцэст тоног төхөөрөмж дансанд 123 нэрийн 1,553.1 сая төгрөг, компьютер дагалдах хэрэгсэл дансанд 34 нэрийн 203.6 сая төгрөг, нийт 1,756.7 сая төгрөгийн бүртгэлээрх ашиглалтын хугацаа дуусч, анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна. Өмч хамгаалах зөвлөлөөс хөрөнгийн ашиглалтын хугацаа болон балансын үнийг шинэчлэн тогтоох саналыг хэлэлцэн боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	1,756,793.7			1	1,756,793.7						
5	Санхүүгийн тайлангийн татварын өр төлбөрийн үлдэгдлийг татварын тодорхойлолттой тулгахад нийт дүнгээр 357.2 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан. Нэмэгдсэн өртгийн албан татварын болон Хувь хүний орлогын албан татварын өрийн зөрүүг тооцоо нийлээгүй байна.	1	-					1	-				
6	Нэр бүхий байгууллагаас 2024 онд худалдан авсан татварын бүртгэлийн програмд бүртгэлээ хөтлөөгүй, өөрийн байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн хөгжүүлээгүй, хөрөнгийг ашиглаагүй байна.	1	-					1	-				
<b>Дүн</b>		<b>6</b>	<b>7,982,498.5</b>	-	-	<b>3</b>	<b>2,506,211.4</b>	<b>2</b>	-	<b>1</b>	<b>5,476,287.1</b>	-	-

Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын тайлан

**6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 28 төрлийн 170 мэдээг тогтоосон хугацаанд нь мэдээлсэн боловч оруулсан мэдээллийн чанар, үнэн зөв байдлыг шалгахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1-ээс 11 дүгээр саруудын гүйлгээний түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарыг хавсаргаагүй, өмнөх аудитаар өгсөн 866/АО150053 дугаартай шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	1	-			1	-		
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт									
2	Зам тээврийн яаманд 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 1/1570 дугаар албан бичгээр хүргүүлсэн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийг тусгасан ч гүйцэтгэлийг хувиар илэрхийлсэн. Мөн тайланд нийт төсөв болон гүйцэтгэлийн хувийг тайлагнаагүй, Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай уялдуулаагүй байна.	1	-					1	-
3	Захирлын 2024 оны А/96 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж батлуулсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлого нь Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, холбогдох хууль тогтоомж болон байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нийцээгүй, санхүүгийн ажилтнуудад гарын авлага зааварчлага байх шаардлагыг хангаагүй байна	1	-					1	-
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 866/АД150053

Улаанбаатар хот

САГ-2026/30/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд ажил гүйлгээ гарсан 4 банкны 7 харилцах, 2 хадгаламж, нийт 9 дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахаар хүргүүлсэн захидлыг банкуудад хүргүүлээгүй, аудитын хугацаанд хариу ирүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 7-д "Банкны байгууллагаас бүх төрлийн харилцах дансны хуулгыг авах бүрдээ дансны гүйлгээг шалгаж, улирал бүрийн дансны үлдэгдлийг батлах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Банкин дахь дансны үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын захирал /Д.Оюунболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Энхчимэг/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 865/АД150053

Улаанбаатар хот

САГ - 2026/30/НА-СТА - ТӨҮГ

Зөрчлийн арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайлангийн авлагын дансны үлдэгдэлд 59 байгууллага, хувь хүмүүсийн 749,417,689.00 / Долоон зуун дөчин есөн сая дөрвөн зуун арван долоон мянга зургаан зуун наян есөн / төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. Авлагын дансны нийт үлдэгдлээс түүвэрлэн 4 байгууллагын үлдэгдлийг тулган баталгаажуулахаар хүргүүлсэн захидлыг харилцагч байгууллагуудад явуулаагүй, аудитын хугацаанд хариу ирүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайлан дахь авлагын дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын захирал /Д.Оюунболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Энхчимэг/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 864/АД150053

Улаанбаатар хот

САГ-2026/30/НА -СТА -ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант жилийн эцэст тоног төхөөрөмж дансанд 123 нэрийн 1,553,146,900.00 /нэг тэр бум таван зуун тавин гурван сая нэг зуун дөчин зургаан мянга есөн зуун/ төгрөг, компьютер дагалдах хэрэгсэл дансанд 34 нэрийн 203,646,840.00 /хоёр зуун гурван сая зургаан зуун дөчин зургаан мянга найман зуун дөчин/ төгрөг, нийт 1,756,793,740.00 /нэг тэр бум долоон зуун тавин зургаан сая долоон зуун ерэн гурван мянга долоон зуун дөчин/ төгрөгийн бүртгэлээрх ашиглалтын хугацаа дуусч, анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн хөрөнгө бүртгэлтэй байна. Өмч хамгаалах зөвлөлөөс хөрөнгийн ашиглалтын хугацаа болон балансын үнийг шинэчлэн тогтоох саналыг хэлэлцэн боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хэмжигдэхүйц байх" зарчмыг баримтлан, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоогоогүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын захирал /Д.Оюунболд/, Ерөнхий нягтлан бодогч /Б.Энхчимэг/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 1479/АО150053

Улаанбаатар хот

САГ-2026/30/КА-СТА-ТӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд орлогын төлөвлөгөө биелүүлээгүй, шилэн дансны цахим хуудсанд орлого, зарлагын гүйлгээний эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хувийг хавсаргаагүй, Автотээврийн үндэсний төвийн лавлагаагаар тус газарт хамааралтай авто тээврийн хэрэгслийг үндсэн хөрөнгөд бүртгээгүй, бусдад ашиглуулсан зөрчлүүдийг давтан гаргаж, өмнөх оны аудитаар өгсөн 866/АО150053, 867/АО150053, 869/АО150053 дугаар зөрчлийг арилгах албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

1. Орлогын төлөвлөгөөг 17,923,892,900.00 /Арван долоон тэрбум есөн зуун хорин гурван сая найман зуун ерэн хоёр мянга есөн зуун/ төгрөгөөр баталснаас 12,447,605,800.00 /Арван хоёр тэрбум дөрвөн зуун дөчин долоон сая зургаан зуун таван мянга найман зуун/ төгрөгийн орлогыг бүрдүүлж, 5,476,287,100.00 /Таван тэрбум дөрвөн зуун далан зургаан сая хоёр зуун наян долоон мянга нэг зуун/ төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан;
2. Шилэн дансны цахим хуудсанд 28 төрлийн 170 мэдээг хуулиар тогтоосон хугацаанд мэдээлсэн боловч оруулсан мэдээллийн чанар, үнэн зөв байдлыг шалгахад 1-11 дүгээр саруудын цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 490,665,123.00 /Дөрвөн зуун ерэн сая зургаан зуун жаран таван мянга нэг зуун хорин гурван/ төгрөг, орлогын 3,644,196,788.00 /Гурван тэрбум зургаан зуун дөчин дөрвөн сая нэг зуун ерэн зургаан мянга долоон зуун наян найман/ төгрөг, нийт 4,134,861,911.00 /Дөрвөн тэрбум нэг зуун гучин дөрвөн сая найман зуун жаран нэгэн мянга есөн зуун арван нэгэн/ төгрөгийн гүйлгээний эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарыг хавсаргаагүй;
3. Авто тээврийн үндэсний төвийн лавлагаанд тус төвд бүртгэлтэй 2 автомашиныг байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй, Авто замын засвар ашиглалтын нэгтгэл ТӨХК-ийн төв салбарт ашиглаж байгаа бөгөөд эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр бусдад ашиглуулсан;
4. Өмнөх оны аудитаар Зам, тээврийн яамнаас Азийн хөгжлийн банкны санхүүжилтийн хүрээнд нэр бүхий байгууллагаас нийлүүлэн 5 тээврийн хэрэгслийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр шилжүүлэн авч, данс бүртгэлд тусгах, зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх


бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16.1-д "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 20 дугаар зүйлийн 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах"; 11 дүгээр зүйлийн 11.3-т "төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны орлогын төлөвлөгөө биелүүлээгүй, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, хөрөнгийн бүртгэлтэй холбоотой зөрчлийг арилгах, таслан зогсоох албан шаардлагуудыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын захирал /Д.Оюунболд/-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга /Б.Цэнгэл/-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ



Д.БАЯРСАЙХАН  
Д.ЭНХДАЛАЙ

Н.ДЭЛГЭРМАА